



дөлгөөн хаирхан уул
АУДИТ ХХК

“ХАРХОРИН” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ П.УЧРАЛ ТАНАА

Нягтлан бодох бүртгэл, аудит, санхүүгийн
хөндлөнгийн хяналтын байгууллага

Хаяг: Оверхангай аймаг, Арвайхээр сум, 5-р баг,
Бизнес хөгжлийн төв, 105 тоот
Утас: 99012943, 99329926

E-Mail: dulguunkhairkhan_audit@timgol.net

2015-02-03 № 08

танай _____-ны № _____-т

Хараат бус аудиторын тайлан

Санхүүгийн тайлангийн тухай

Бид “Хархорин” ХК-ийн 2014 оны 12 сарын 31-нээрх баланс, тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын, өмчийн өөрчлөлтийн болон мөнгөн гүйлгээний тайланг аудитлалаа.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах нь компанийн удирдлагын үүрэг байна. Энэхүү үүрэг, хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, нягтлан бодох бүртгэлийн тооцоолуудыг хийх замаар аливаа алдаа, залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайланг бэлтгэх, толилуулахтай холбоотой дотоод хяналтын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэх үүрэг хариуцлагууд багтана.

Аудиторын хүлээх хариуцлага

Бидний үүрэг, хариуцлага бол хийж гүйцэтгэсэн аудитдаа үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх явдал юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэхүү стандартаар санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилтэй илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй магадлагаа олж авахын тулд аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон санхүүгийн тайлангийн тодруулгыг нотлох зүйл олж авах горимуудыг гүйцэтгэх ажил орно. Аудитын явцад компанид хэрэглэгдэж байгаа нягтлан бодох бүртгэлийн зарчмууд, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой тооцоол, санхүүгийн тайлангуудын бодитой эсэхэд үнэлэлт өгөв.

Бидний олж авсан нотлох зүйл нь энэхүү гаргасан дүгнэлтэд зохистой үндэслэл болж чадна гэдэгт итгэлтэй байна.

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр, “Хархорин” ХК-ийн 2014 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн тайлангууд нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Хүндэтгэсэн,

Салбарын захирал

Д.Дашзэвэг

